



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
Төрийн Өмчит Хувьцаат Компани

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/114

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.3, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/154 дүгээр тушаалаар батлагдсан "Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм", компанийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Суурь бүтцээр тээвэрлэх ачааны захиалга хүлээн авах журам"-ыг нэгдүгээр, "Төмөр замаар ачаа тээвэрлүүлэгчийн бүрдүүлэх материалын жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тээвэр, ложистикийн газар /Г.Цолмонбаяр/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер /Т.Батзориг/-т тус тус үүрэг болгосугай.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ОТГОНСҮХ

2023001103

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2023 оны 08-дугаар сарын 25-ны өдрийн
А/114... дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт



СУУРЬ БҮТЦЭЭР ТЭЭВЭРЛЭХ АЧААНЫ ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Төмөр замын тээврийн тухай хууль, Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/154 дүгээр тушаалаар батлагдсан “Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм” болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК-ийн суурь бүтцээр тээвэрлэх ачааны захиалга хүлээн авах харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1 “Монголын төмөр зам” ТӨХК /цаашид “Тээвэрлэгч” гэх/-д суурь бүтцээр ачаа тээвэрлүүлэх хүсэлт илгээсэн аж ахуйн нэгж байгууллагууд хамаарна.

Гурав. Ачаа захиалга хүлээн авах шаардлага

3.1. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч /цаашид “үйлчлүүлэгч” гэх/ нь энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан “Төмөр замаар ачаа тээвэрлүүлэгчийн бүрдүүлэх материалын жагсаалт”-д заасан шаардлагын дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлж, хүсэлтийн хамт тээвэрлэгч байгууллагын эрх бүхий албан тушаалтанд албан бичгээр ирүүлнэ.

3.2. Тээвэрлэгч нь материал ирүүлсэн үйлчлүүлэгчдийн басимт бичгийн бүрдлийг шалгаж, шаардлага хангасан үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулах эсэх талаар мэдэгдэнэ.

3.3. Шаардлага хангасан үйлчлүүлэгчтэй “Төмөр замаар ачаа тээвэрлэх гэрээ” байгуулна. Хэрэв үйлчлүүлэгч нь өөрийн хөдлөх бүсэлдэхүүнтэй тохимолдолд эзэмшлийн бус хөдлөх бүрэлдэхүүнийг төмөр замын тээвэрт сролцуулах гэрээг нэмэлтээр байгуулна.

3.4. Үйлчлүүлэгч нь гэрээнд заасан хугацаанд батлагдсан тарифын дагуу тээврийн хөлсийг тээвэрлэгчийн дансанд урьдчилан бүрэн байршуулна.

3.5. Үйлчлүүлэгч нь тээврийн хөлсийг бүрэн төлснөөс тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцох эрх баталгаажна.

3.6. Тээвэрлэгч нь үйлчлүүлэгчдийг тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцох эрх баталгаажсан хугацаагаар эрэмбэлэн, тээвэрлэлтийн төлөвлөгөөнд оруулна.

Тээвэрлэх ачааг эрэмбэлэхдээ:

3.6.1 Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр үүрэг болгосон нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий ачаа

3.6.2 Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ачаа.

3.6.3 Цахилгаан эрчим хүч, Дулаан хангамжтай холбоотой нэн шаардлагатай түүхий эд бараа, материал.

3.6.4 Суурь бүтцийг ашиглаж тээвэрлүүлэх захиалга өгсөн бусад байгууллагын ачаа.

3.7. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн төлөвлөгөөг тухайн сарын 20-ны өдрийн дотор энэхүү журмын 3.5-т заасан ачааны захиалгыг үндэслэн өөрийн технологийн хүчин чадалд

тулгуурлан баталж цахим хуудсанд байршуулна. Цахим хуудсанд байршуулсан захиалгын мэдээллийг 7 хоног бүр шинэчилнэ.


3.8. Тээвэрлэлтийн төлөвлөгөөнд орсон гэрээ байгуулсан үйлчлүүлэгч нь тухайн сардаа ачаагаа тээвэрлээгүй, тээвэрлүүлээгүй тохиолдолд тээвэрлэлтийн төлөвлөгөөний дарааллын хамгийн сүүлд байршина.

3.9. Гэрээ байгуулсан үйлчлүүлэгчийн тээвэрлүүлэх ачааны нийт хэмжээ 20,000 тн хүртэл байна.

3.10. Гэрээ байгуулсан үйлчлүүлэгч нь "Төмөр замаар ачаа тээвэрлэх гэрээ" дуусгавар болсны дараа дахин хүсэлт ирүүлсэн тохиолдолд гэрээний дүгнэлтийг харгалзан журмын 3.9-д заасан хэмжээгээр сард гурваас дээшгүй удаа тээвэрлэж болно.

----aOo----

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн
А/114... дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт



ТӨМӨР ЗАМААР АЧАА ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Төмөр замаар ачаа тээвэрлүүлэх гэрээ:

1. Тээвэрлэлт хийлгэх тухай хүсэлт;
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
3. Гүйцэтгэх удирдлага, захирлын иргэний үнэмлэхийн хуулбар;
4. Хэрэв гэрээнд захирлаас өөр этгээд гарын үсэг зурах тохиолдолд түүнд олгосон итгэмжлэл, бүрэн эрхийн нотолгоог хавсаргах;
5. Тээвэрлэх ачааны талаарх мэдээлэл;
6. Тээвэрлэлтийн төлөвлөгөө;
7. Тээвэрлэх ачааны худалдах, худалдан авах гэрээний хуулбар.

Эзэмшлийн бус хөдлөх бүрэлдэхүүнийг төмөр замын тээвэрт оролцуулах гэрээ:

1. Эзэмшигчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
2. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээний хуулбар;
3. Гүйцэтгэх удирдлагын иргэний үнэмлэхийн хуулбар
4. Хэрвээ гэрээнд гүйцэтгэх удирдлагаас өөр этгээд гарын үсэг зурах тохиолдолд түүнд олгосон итгэмжлэл;
5. Монгол Улсын төмөр замын тээвэрт хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр буюу зөвшөөрөл;
6. Хөдлөх бүрэлдэхүүний өмчлөгч, эзэмшигчийг нотолсон баримт, гэрчилгээ хэрэв түүний өмчлөгч, эзэмшигч биш бол түүнийг эзэмших, ашиглах эрх үүсгэсэн баримт бичиг /түрээсэлсэн тохислдолд түрээсийн гэрээ/;
7. Хөдлөх бүрэлдэхүүний техникийн нөхцөл, техникийн паспортын мэдээллийн дагуу үйлдсэн жагсаалт /Хавсралт 1/;
8. Өөрийн эзэмшлийн салбар замгүй тохиолдолд салбар зам эзэмшигч этгээдтэй байгуулсан Салбар зам ашиглах түрээсийн гэрээ;
9. Төмөр замын тээвэрлэлттэй холбогдсон ажил, үйлчилгээний хөлс, төлбөрийг тогтоосон тарифын дагуу Тээвэрлэгчийн харилцах банкны дансанд урьдчилан төлсөн байх, төлбөрийн баримтыг хавсаргах.

----oOo----